

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/012/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН АРХУСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Хатанбаатар

Утас: 70272287 Цахим хаяг: khatanbaatarga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зүүнмод сум
Утас 70272582, Холбоо утас: 70272582, 70272583
Цалин хаяг: www.audit.mn

2025.03.24 № 01/141
Танай _____ -ны № _____ -г

ТӨВ АЙМГИЙН АРХУСТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Э.ЭНХТӨМӨР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Архуст сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрчимжсэн мал ахуй фермерийг нэмэгдүүлэх, нийлүүлэгчээс үйлдвэрлэгч болох зорилго тавьж тэжээлийн үйлдвэрлэл эрхлэгч, үйлдвэрлэлийг бий болгох, өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжих үүднээс дундын техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, төмс, хүнсний ногооны агуулах зоорьтой болох үүднээс 2024 онд газар тариаланг эрчимтэй хөгжүүлж Төв аймаг, улсын хэмжээнд тэргүүлэн ажиллаж байна. 2022 оны 12 сард аймаг улсын хөрөнгө оруулалтаар газар тариалангийн дундын техникийг дэмжин 53,309,0 мянган төгрөгийн техник, 2024 онд орон нутгийн шилжих үлдэгдлээс 18,000.0 мянган төгрөгийн үрлэгч техник авсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд орон нутгийн хөгжлийн сан болон шилжих үлдэгдлээс иргэний танхимын тохижилт 15,900.0 мянган төгрөг, ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл зүйн кабинетын тохижилт 20,000.0 мянган төгрөг, сум дундын техник 18,000.0 мянган төгрөг, сумын төвийн камержуулалд 17,000.0 мянган төгрөг, нийтийн эзэмшлийн талбайд цахилгааны утас татах, засварлах 17,100.0 мянган төгрөг, цөм сүргийг нэмэгдүүлэх, үүлдэр угсаа сайжруулах 19,000.0 мянган төгрөг, хогийн менежмент сайжруулах 19,000.0 мянган төгрөг, нийтийн бие засах газар 43,600.0 мянган төгрөгийн нийгмийн салбарт дээрх хөрөнгө оруулалт хийсэн байна.

412596434

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүнг 90 хувь, сумын урианы жилийн төлөвлөгөөг 11 зорилтын хүрээнд 50 хэрэгжүүлэх арга хэмжээтэй баталснаас 38 арга хэмжээ 100 хувьтай, 12 арга хэмжээ 70 хувьтай, нийт 94.5 хувьтай тус тус хэрэгжүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/				
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		524,393.5	744,260.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	119,255.5	174,394.2
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	288,890.3	378,896.7
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	116,247.7	190,969.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,589,865.2	1,834,436.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,589,865.2	1,834,436.0
39200	Биет хөрөнгө		1,355,477.2	1,590,364.6
39300	Биет бус хөрөнгө	13	234,388.0	244,071.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,114,258.7	2,578,696.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		9,922.3	8,280.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	9,922.3	8,280.0
41300	Өглөг	17а, 17б	9,922.3	8,280.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,104,336.5	2,570,416.8
51	Засгийн газрын хувь оролцоо		2,104,336.5	2,570,416.8
51100	Засгийн газрын оруулсан капитал		825,219.3	825,219.3
51200	Хуримтлагдсан үр дүн		1,151,062.5	1,617,142.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		128,054.7	128,054.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,114,258.7	2,578,696.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/				
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		1,866,235.8	1,957,287.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО		285,094.8	391,050.5
110	Орлогын албан татвар		202,482.4	337,404.0
1100	Хувь хүний орлогын албан татвар		207,482.4	337,404.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-5,000.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар		28,234.0	22,751.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж		54,378.4	30,895.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	231,376.2	295,473.8
120	Нийтлэг татварын бус орлого		231,376.2	295,473.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,349,764.8	1,270,762.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,682,522.4	1,254,487.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,680,764.4	1,245,487.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		924,292.0	1,210,592.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		411,355.8	656,130.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		54,817.1	85,344.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		54,117.7	74,895.7
2104	Хангамж, бараа материалын зардал		40,789.2	45,862.1
2105	Нормативт зардал		49,726.2	50,728.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		3,915.0	11,300.0
2107	Томилот, зочны зардал		7,511.4	8,996.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		8,698.4	14,266.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		293,361.2	263,070.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		756,472.4	34,894.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,758.0	9,000.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		183,713.3	702,800.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		146,469.1	226,480.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		37,244.2	476,319.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/	
		Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,067,092.2	2,067,092.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,448.2	2,448.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,069,540.4	2,069,540.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-2,448.2	-2,448.2
9	Тайлант үеийн үр дүн	37,244.2	37,244.2
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,104,336.5	2,104,336.5
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,104,336.5	2,104,336.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	8,939.5	8,939.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,113,276.0	2,113,276.0
19	Тайлант үеийн үр дүн	457,140.8	457,140.8
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,570,416.8	2,570,416.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/	
		2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,770,409.0	1,843,685.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	285,094.8	391,050.5
110	Орлогын албан татвар	202,482.4	337,404.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	207,482.4	337,404.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-5,000.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар	28,234.0	22,751.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	54,378.4	30,895.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,737.7	3,811.8
1181	Газрын төлбөр	49,874.6	27,083.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	766.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	135,549.5	201,050.7
120	Нийтлэг татварын бус орлого	135,549.5	201,050.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,349,764.8	1,251,584.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,494,025.7	1,083,762.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,494,025.7	1,083,762.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	737,553.3	1,048,471.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	416,658.6	664,908.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,229.4	84,304.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,382.1	165,552.1
2104	Хангамж, бараа материалын зардал	19,699.1	33,216.2
2105	Нормативт зардал	50,616.6	44,454.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,300.0	25,800.0
2107	Томилолт, зочны зардал	7,511.4	8,996.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,080.1	12,937.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	126,076.0	8,302.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	756,472.4	35,290.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	276,383.3	759,923.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	195,060.2	542,619.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	195,060.2	542,619.7
2200	Дотоод эх үүсвэрээр	195,060.2	542,619.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-195,060.2	-542,619.7
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-125,230.2	-162,165.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	125,230.2	162,165.2
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-43,907.2	55,138.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	163,162.7	119,255.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	119,255.5	174,394.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,529,196.9	1,404,261.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,002,928.8	962,707.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	992,820.8	952,599.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	612,496.8	595,523.6
210101	Үндсэн цалин	269,390.6	330,999.5
210102	Нэмэгдэл	247,258.8	165,394.3
210104	Урамшуулал	20,513.8	23,796.2
210105	Гэрээт ажлын хөлс	75,333.6	75,333.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,562.3	75,959.9
210201	Тэтгэврийн даатгал	52,062.3	51,459.9
210202	Тэтгэмжийн даатгал	6,125.0	6,125.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,062.5	3,062.5
210204	Ажилгүйдлийн даатгал	3,062.5	3,062.5
210205	Эрүүл мэндийн даатгал	12,250.0	12,250.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185,772.9	165,552.1
210301	Гэрэл, цахилгаан	71,532.1	69,136.3
210302	Түлш, халаалт	111,193.8	94,011.1
210303	Цэвэр, бохир ус	3,047.0	2,404.8
2104	Хангамж, бараа материалын зардал	27,702.8	27,698.9
210401	Бичиг хэрэг	4,106.2	4,642.5
210402	Тээвэр, шатахуун	16,780.6	16,620.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,236.0	3,236.0
210404	Ном, хэвлэл	380.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200.0	3,200.0
2105	Нормативт зардал	690.0	682.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	690.0	682.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,300.0	44,120.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500.0	2,420.0
210604	Урсгал засвар	41,800.0	41,700.0
2107	Томилолт, зочны зардал	9,018.0	8,486.0
210702	Дотоод албан томилолт	9,018.0	8,486.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,643.0	24,274.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,450.0	15,450.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648.0	648.0
210803	Даатгалын үйлчилгээ	586.0	504.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.0	198.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400.0	142.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,000.0	7,000.0
210807	Газрын төлбөр	332.0	331.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,635.0	10,301.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000.0	8,666.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,635.0	1,635.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,108.0	10,108.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,108.0	10,108.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,608.0	6,608.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500.0	3,500.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	326,268.1	279,389.3
222001	Тоног төхөөрөмж	161,700.0	110,889.3
223001	Бусад хөрөнгө	164,568.1	168,500.0

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	200,000.0	162,165.3
230001	Эргэж төлөгдөх зээл	200,000.0	162,165.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,529,196.9	1,394,941.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	245,268.1	-
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	245,268.1	-
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,026,928.8	1,270,161.2
320001	Орон нутгийн төсвөөс	1,026,928.8	1,031,231.3
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	238,929.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	257,000.0	124,780.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.0	124,780.6
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	57,000.0	-
4	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	61,997.1
5	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	38,366.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	56	56
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	Төсвийн байгууллага	2	2
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27	27
620001	Удирдах ажилтан	7	7
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	5	5
620004	Гэрээт ажилтан	6	6
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27	27
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5
650010	Гэрээт ажилтан	6	6
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5	5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр /	
		Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,977.4	342,985.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,977.4	112,524.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	35,193.3	83,956.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,628.9	69,384.6
210101	Үндсэн цалин	-	2,050.7
210102	Нэмэгдэл	28,628.9	65,616.2
210105	Гэрээт ажлын хөлс	-	1,717.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,421.3	8,344.7
210201	Тэтгэврийн даатгал	868.2	5,679.4
210202	Тэтгэмжийн даатгал	149.2	668.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	122.1	393.8
210204	Ажилгүйдлийн даатгал	59.8	273.2
210205	Эрүүл мэндийн даатгал	222.0	1,329.7
2104	Хангамж, бараа материалын зардал	-	5,105.4
210402	Тээвэр, шатахуун	-	5,105.4
2107	Томилолт, зочны зардал	-	510.0
210702	Дотоод албан томилолт	-	510.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45.0	611.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45.0	611.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,098.1	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,098.1	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,784.1	28,568.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	23,647.3
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	23,647.3
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,784.1	4,920.8
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	896.2
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,784.1	4,024.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	230,461.4
2200	Дотоод эх үүсвэрээр	-	230,461.4
222001	Тоног төхөөрөмж	-	230,461.4
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	42,977.4	342,985.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,977.4	342,985.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,502.4	339,600.8
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	475.0	3,385.0

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулах алдаа гараагүй.

Аудитаар нийт 17,890.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн болно.

Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1			1			
3	Хүүхдийн цэцэрлэг	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Эмийн эргэлтийн сан	1		1					
6	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	НИЙТ	6	1	5		1			

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан тай холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Засаг дарга	0	0					0	-				
Засаг даргын тамгын газар	2	252,167.80	1	30,068.0	1	222,099.8	2	252,167.8				
Дүн	2	252,167.8	1	30,068.0	1	222,099.8	2	252,167.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Засаг дарга	2	17,890.7			-	1	-	1	17,890.7
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	3	2,282.7	2	2,282.7				1	-
Засаг даргын тамгын газар	6	8,443.1	2	3,690.6	2	4,752.5	2	2	-
Хоршоо хөгжүүлэх сан	1	8,577.8						1	8,577.8
Эмийн эргэлтийн сан	2	447.0				2	447.0		
Цэцэрлэг	3	7,885.3	1	3,443.5	2	4,441.8			
Дүн	14	37,641.3	4	5,973.3	5	5,199.5	5	26,468.5	